



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/41

Мөрөн сум

Малын гоц халдварт шүлхий өвчний
дархлаажуулалтын ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын “Шүлхий өвчнөөс сэргийлэх яаралтай дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай” 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн А/41 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтыг шүлхий өвчний эрсдэл бүхий сумдын тархалтыг хязгаарлах, халдварлалтыг бууруулах уг өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тухайн өвчний тархвар зүйн судалгаанд үндэслэн 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн 10 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулсугай.

2. Дархлаажуулалтын арга хэмжээний ажлын хэсгийг шуурхай зохион байгуулж, шаардагдах ажиллах хүн хүч, шатахуун, автомашинаар ханган явц, гүйцэтгэлд нь өдөр тутмын хяналт тавьж ажиллахыг холбогдох сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Дархлаажуулалтад шаардагдах вакцин, эм бэлдмэл, хамгаалах хувцас хэрэгслийг хуваарилан олгож, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, тайлан мэдээ, акт баримтыг бүрдүүлэн холбогдох газарт хүргүүлж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Л.Ариунаа), захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



ШИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар
сарын 10 өдрийн А/З.4 дугаар захирамжийн
хавсралт

№	Аймаг	Сум	Олгох вакцин (мян/тун)	Хайрцаг (ширхэг)	Шил (ширхэг)	Цувралын дугаар	Хэрэглэгдэхүүн (ш)	Ариутгалын бодис (кг)
1	Хөвсгөл	Ренчинлхүмбэ	15.0	7	150	020122	2	2
2		Жаргалант	10.0	4	100	020122	2	2
3		Улаан-уул	6.0	3	60	020122	2	2
4		Галт	6.0	3	60	020122	2	2
5		Цэцэрлэг	6.0	3	60	020122	2	2
6		Их-уул	6.0	2	60	020122	2	2
7		Рашаант	5.0	2	50	020122	2	2
8		Баянзүрх	5.0	2	50	020122	2	2
9		Ханх	5.0	2	50	020122	2	2
10		Эрдэнэбулган	4.0	1	40	020122	2	2
11		Цагаан-үүр	4.0	1	40	020122	2	2
12		Тариалан	4.0	1	40	020122	2	2
13		Шинэ-идэр	4.0	1	40	020122	2	2
14		Цагааннуур	3.0	1	30	020122	2	2
15		Хатгал тосгон	2.0	1	20	020122	2	2

оОо